

БАТЛАВ:

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

/Ж.ТАМИР/

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН 17, 20 ДУГААР ХОРООНЫ НУТАГ ДЭВСГЭРТ АЙЛ ӨРХҮҮДИЙН
ЭРЧИМ ХҮЧНИЙ УНАЛТТАЙ ХЭСЭГТ ЦАХИЛГААНЫ ДЭД ӨРТӨӨ ЦАХИЛГААН ШУГАМ
СҮЛЖЭЭНИЙ АЖЛЫН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

2026 оны 01 дүгээр сарын 15-ний өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

1.	Зураг төсөл боловсруулах үндэслэл	- 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн Чингэлтэй дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 25 дугаар тогтоол - Чингэлтэй дүүргийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр; - Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ны 2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн 01/05983/25 дугаар техникийн нөхцөл.
2.	Байршил	Чингэлтэй дүүргийн 17, 20 дугаар хороо
3.	Зориулалт, хүчин чадал	Хүчин чадал – 400кВА.
4.	Зураг төсөл боловсруулах хугацаа	Захиалагч болон гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээнд заасан хугацааг үндэслэл болгоно.
5.	Зураг төсөл боловсруулах байгууллага	- Эрчим хүчний яамны ТЗ-8.3 заалт; - Хот байгуулалт, барилга орон сууцжуулалтын яамны ЗТ-6.3 түүнээс дээш заалттай эрх бүхий хуулийн этгээд
6.	Захиалагч	Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газар
7.	Зураг төсөл боловсруулах үе шат	- Ажлын зураг, төсөв 1 үе шаттай.
8.	Зургийн ажилд тавигдах шаардлага	- Барилгын зураг төсөл боловсруулах, норм дүрэм болон одоогоор мөрдөгдөж буй холбогдох норм дүрмийг баримтлан сүүлийн үеийн дэвшилтэт шийдлүүдийг сонгох; - Ажлын зураг, төсөв боловсруулж, захиалагч байгууллагатай зөвшилцөн, мэргэжлийн байгууллагуудтай зөвшилцөж, магадлал хийлгэх.
9.	Зураг төслийн бүрдэл	Баримт бичгийн иж бүрдэл: • Ажлын зураг төсөл • Төсөв • Магадлалын дүгнэлт • Хэвлэмэл байдлаар 2 хувь, /1 эх, 1 хуулбар/ • CD байдлаар 1 хувь захиалагчид өгнө.
10.	Зураг төсөл боловсруулахад ашиглах материал	Монгол Улсын хуулиуд: - Хот байгуулалтын тухай хууль; - Барилгын тухай Монгол Улсын хууль; - Байгаль орчныг хамгаалах тухай хууль; - Эрчим хүчний тухай хууль; - Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль; - Бусад холбогдох хууль тогтоомжууд. Норм норматив: - Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилт БНБД 30-01-04 - Барилгад хэрэглэгдэх уур амьсгал ба геофизикийн үзүүлэлт БД 23-01-09;

		- Барилгад хэрэглэгдэх уур амьсгал ба геофизикийн үзүүлэлт БД 23-01-09; - Захиалагчийн дүрэм УББ12-201-01; - Цахилгаан байгууламжийн зураг төсөл, угсралтын дүрэм БД 43-101-03; - 0,4-22 кВ-ын хүчдэлийн хуваарилах шугам сүлжээний дэд өртөө барьж байгуулахад тавигдах шаардлага; - 0,4-35 кВ-ын хүчдэлийн хүчний кабель шугам барьж байгуулахад тавигдах ерөнхий шаардлага; - Орон сууцны хороолол, хотхоны 6-10 кВ-ын сүлжээ болон РП, ТП-үүд /УБЦТС ТӨХК-ийн Техникийн шаардлагын тодорхойлолт:РП,ТП/; - Барилгын орчны тохижилтын ажил БНБД 3.01.06-90 - Барилгын ажлын явцад зохиогчийн хяналт тавих дүрэм БНБД 11-04-99; - Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрэм; - Монгол улсын Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 18-ний өдрийн 97 дугаар тогтоолоор баталсан "Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм", "Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм"; - Бусад холбогдох норм дүрэм, стандартууд.
11.	Галын аюулгүй байдлын нөхцөл	- Барилга байгууламжийн галын аюулгүй байдал БНБД 21-01-02; - Барилга, байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүйн норм БНБД 21-02-02.
12.	Эдийн засгийн тооцоо, төсөв	Төсвийг ESTIMATOR-PRO программ болон зохих эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн бусад программаар тооцох.
13.	Онцгой нөхцөл	- Дэвсгэр зургийн тодруулга хийх; - Техникийн нөхцөлийн дагуу ажлын зураг төслийг хийж гүйцэтгэх; - Авто зам болон үерийн далан сувагтай хөндлөн огтлолцсон хэсгийн зүсэлтийн зургийг ажлын зурагт тусгах; - Цахилгааны шонг хадархаг буюу хадан хөрсөнд стандартын шаардлагын дагуу суурилуулах; - Шаардлагатай тохиолдолд зураг төсөл гүйцэтгэгч байгууллага тухайн байршил дээр очиж газар дээр нь хангагч байгууллагатай зөвшилцөн техникийн нөхцөлийг баталгаажуулж, трассыг зөвшилцөх; - Ажлын зураг төсөлд авто зам, явган зам, ногоон байгууламж, тохижилтын ажлыг нөхөн сэргээх зардлыг холбогдох дүрэм журам, үнэлгээний дагуу тооцон төсөвт тусгах; - Батлагдсан зураг төслийн дагуу барилга угсралтын ажил гүйцэтгэх.

ХЯНАСАН:

Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын
хэлтсийн дарга

 М.Цогтбилэг

БОЛОВСРУУЛСАН:

Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын
хэлтсийн мэргэжилтэн

 М.Отгонбат



ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ

Дугаар 01/05983/25

2025 оны 11 сарын 5 өдөр

Улаанбаатар хот

Нэг. Ерөнхий мэдээлэл

1.1	Хүсэлтийн дугаар	251000930
1.2	Хэрэглэгчийн нэр, регистр:	ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР, РД:9114831
1.3	Хэрэглэгчийн байршил:	Улаанбаатар Чингэлтэй дүүргийн 17, 20, 22 дугаар хороо
1.4	Ажил үйлчилгээний зориулалт:	Инженерийн байгууламж
1.5	Техникийн нөхцөл олгох үндэслэл:	1.5.1) Хүчдэлийн уналттай айл өрхүүд 1.5.2) Чингэлтэй дүүргийн засаг даргын тамгын газар 2025-10-07-ны өдрийн 03/2940 тоот албан бичиг
1.6	Техникийн нөхцөлийн ангилал:	Шинэ холболт
1.7	Суурилагдсан хүчин чадал	400 кВА (Дөрвөн зуун кВА)
1.8	Хүчдэлийн түвшин	10кВ

Хоёр. Холболтын цэг

2.1	35/10 кВ-ын Хөгжил дэд станцын 10 кВ-ын Бор толгой фидерийн тулгуур № 27-с салбарлалт авч салбар шугамын эхний тулгуурт хуурай салгуур суурилуулан бүрээстэй агаарын шугам /кабель шугам/ татаж шинээр баригдах дэд өртөөг тэжээх.
2.2	110/35/10 кВ-ын Телевиз дэд станцын 10 кВ-ын Мөрөн фидерийн тулгуур № 78-с салбарлалт авч салбар шугамын эхний тулгуурт хуурай салгуур суурилуулан бүрээстэй агаарын шугам /кабель шугам/ татаж шинээр баригдах дэд өртөөг тэжээх.
2.3	110/35/10 кВ-ын Дарь Эх дэд станцын 10 кВ-ын Сурагч фидерийн тулгуур № 151-с салбарлалт авч салбар шугамын эхний тулгуурт хуурай салгуур суурилуулан шинэ технологийн өндөр дамжууламж бүхий SAX-W-70 маркийн бүрээстэй агаарын шугам /кабель шугам/ татаж шинээр баригдах дэд өртөөг тэжээх.

Гурав. Тоолуур, хэмжих хэрэгсэл:

3.1	Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг-Стандарт, хэмжилзүйн https://gerel.tog.mn/tncshow/BBB15241-97BC-4C07-8052-9696B7A223C6
-----	---

- 4.7 Тухайн байршилд одоо байгаа дэд өртөөний ачааллыг шилжүүлэхдээ харъяа түгээх төв болон хэрэглэгчдэд үйлчлэх төвөөр хяналт тавиулан шинээр баригдсан дэд өртөөний 0.4 кВ-ын гаргалга шугамд шилжүүлэх.
- 4.8 Техникийн нөхцөлийн дагуу шинээр суурилуулах тоноглолууд нь өмнө ашиглагдаж байгаагүй шинэ байх, кабель шугам, трансформаторууд нь сүүлийн үеийн байгаль орчинд ээлтэй, дэвшилтэд техник технологи бүхий байх. Нэгдсэн сүлжээний дүрэмд заасны дагуу $\pm 10\%$ -ийн хүчдлийн хэлбэлзэлд хэвийн ажиллах.
- 4.9 Шугам, дэд станцын гүйцэтгэлийн зургийг гаргаж, ашиглагч байгууллага УБЦТС ТӨХК-д хүлээлгэн өгөх, гүйцэтгэлийн зургийг гаргахдаа кабель шугамын холболтын муфтуудыг заасан, бусад инженерийн шугам сүлжээ, авто замтай огтлолцсон хэсгийн зүсэлтийг тусгах.
- 4.10 Дэд өртөөний бүх тоноглол, гаргалга кабель шугамууд болон агаарын шугамын тулгуур бүрт НСД, ААД, ТАД-д заагдсаны дагуу хаягжилт, плакатжуулах ажлыг гүйцэтгэсэн байна.
- 4.11 Дэд өртөөнүүдийн 0.4 кВ-ын агаарын шугамын уулзвар цэгт рубильник суурилуулах. Техникийн тодорхойлолтыг Техникийн бодлого зохицуулалтын хэлтсээс авах.
- 4.12 Барилга угсралтын ажлын зураг нь ЦБД, ТАД, ААД, ЭХ-ний шугам сүлжээг хамгаалах дүрэм, ЭХ хэрэглэх дүрэм болон УБЦТС ТӨХК-аас хэрэгжүүлж байгаа ашиглалт борлуулалтын арга хэмжээний шаардлагуудыг хангасан байна.
- 4.13 Буусан тоног төхөөрөмжийг Монгол улсын засгийн газрын 2020 оны 97-р тогтоолын 2.7.2-т заасны дагуу УБЦТС ТӨХК-ийн үндсэн хөрөнгөнд шилжүүлэн өгөх.
- 4.14 Шинээр баригдах цахилгаан дамжуулах кабель шугам нь:
- 4.14.1) Шинээр татах 10 кВ-ын кабель шугам нь MNS 6819:2015 стандартын шаардлагыг хангасан байх.
- 4.14.2) Шинээр татах 10 кВ-ын кабель шугамын хөндлөн огтлолыг хэрэглээ ачаалалтай уялдуулан зураг төслийн шатанд тооцоогоор сонгох, ашиглагч "УБЦТС" ТӨХК-тай зөвшилцөх.
- 4.14.3) Кабелиуд нь 10 кВ-ын хүчдлийн түвшинд ашиглах, орчны температур -15 хэм байхад угсралт хийх боломжтой байх.
- 4.15 Шинээр баригдах цахилгаан дамжуулах агаарын шугам нь:
- 4.15.1) Цахилгаан дамжуулах агаарын шугамын үндсэн хийц болох анкер болон завсрын тулгуур нь төмөр болон төмөр бетон байх
- 4.15.2) Дамжуулагч нь бүрээстэй байх ба хөндлөн огтлолыг ачаалалтай уялдуулан, тооцоогоор сонгох, мөн утасны механик ачаалалд тохирсон үндсэн хийцүүд, хөндийрүүлэгч элементүүдийг тооцоогоор сонгох
- 4.15.3) Цахилгаан дамжуулах агаарын шугамын үндсэн хийцүүд, дамжуулагч утас, хөндийрүүлэгч элементүүд, утас угсралтын тоног төхөөрөмжүүд нь Монгол улсын стандартын шаардлага хангасан байх, тухайн газрын байгаль цаг уур, газарзүйн онцлогийг харгалзан зураг төслөөр сонгох.
- 4.16 Түгээх сүлжээний төлөвлөлт, горимын онцгой ач холбогдол бүхий нийтийн сүлжээ, магистраль шугам үүсгэхээр газарт техникийн нөхцөл олгосон тул шинээр баригдах дэд станц, цахилгаан дамжуулах шугам, тоноглолоос хангагч байгууллага нь горимын найдвартай ажиллагааг хангах зорилгоор бусад иргэн, хуулийн этгээдэд техникийн нөхцөл олгохыг анхаарна уу.

Тав. Дор дурдсан техникийн даалгавар, хууль дүрмийг мөрдөх:

- 5.15** | Цахилгаан эрчим хүчний тооцоог Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ төрийн өмчит хувьцаат компанийн харьяа хэрэглэгчдэд үйлчлэх төвтэй хийх.

Зургаа. Бусад:

- 6.1** | Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 97 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн 2.17-д заасан доорх заалтуудыг мөрдлөг болгоно. Дараах тохиолдолд олгосон техникийн нөхцөлийг хүчингүйд тооцно. Үүнд:
- 6.1.1) Техникийн нөхцөл авахдаа шаардлагатай өгөгдлүүдийг буруу тодорхойлсон, баримт бичгийг хуурамчаар үйлдсэн тохиолдолд.
 - 6.1.2) Холболт хийх цэгийн хүчин чадлаас хэтрүүлэн техникийн нөхцөл олгосон.
 - 6.1.3) Техникийн нөхцлийн хүчинтэй байх хугацаанд цахилгааны сүлжээнд холбогдоогүй тохиолдолд.
 - 6.1.4) Хугацаа дууссан техникийн нөхцөлөөр зураг төсөл боловсруулах, барилга байгууламж барихыг хориглоно.
 - 6.1.5) Техникийн нөхцөлийн хүчинтэй хугацаа дуусахаас 2 сарын өмнө сунгуулах хүсэлтээ гаргана. Хугацаа дууссан техникийн нөхцөлийг хүчингүй тооцно.
 - 6.1.6) Техникийн нөхцөлийн олгосон чадлаас хэтрүүлэн чадал ашигласан тохиолдолд.
- 6.2** | Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 97 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн 2.9-д заасны дагуу 1 жилийн хугацаанд хүчинтэй байна.
- 6.3** | Техникийн нөхцөлийн хугацааг сунгуулах тохиолдолд Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 97 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн 2.13, 2.16-д заасны дагуу зураг төслийг боловсруулан баталгаажуулсан байна.



Чингэлтэй дүүргийн 17, 20 дугаар хорооны хүчдэлийн уналттай айл өрх

